

ФОРМАЛ СЭТГЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ, ХЯЗГААРЫН ТУХАЙ ГЕГЕЛИЙН ҮЗЭЛ САНАА

Г.Лодой - МУИС,НШУС, Философийн тэнхим, доктор профессор

Түлхүүр үг: формал логикийн хууль, диалектик логик, сэтгэхүйн зөрчил, диалектик аргын үе шатуу, диалектикийн гурвал.

Гегелийн диалектикийг формал логикт сөргүүлэн тавих гэсэн оролдлого эдүгэ болтол үргэлжилсээр байгаа бөгөөд үүний шалтгаан нь уламжлалт логикийн талаар түүний зарим үндэслэлүүдтэй холбоотой юм. Гегель формал логикийг үгүйсгээгүй боловч түүний үүрэг, ач холбогдлын тухай шүүмжлэлтэй хандсан зүйл цөөнгүй байдаг. Тухайлбал, “Логикийн ухаан” зохиолынхоо “Мөн чанарын тухай сургаал”-ын хэсэг формал логикийн хуулиудыг шүүн шинжилсэн байдаг. Адилтгалын хууль бол тавтолог шинжтэй болохыг тэмдэглээд, энэ хуулийг баримталваас гариг бол гариг, хүн бол хүн гэсэн маягийн үнэнийг номлоход хүргэх бөгөөд ийм баримтлал эрүүл сэтгэлгээ боло оюун ухаанд тохиромжгүй болохыг анхааруулан шүүмжилсэн буй.

Мөн түүнчлэн зөрчлийн хуулийн суурь үндэслэл нь метафизик шинжтэй, зохисто бус болохыг тэмдэглэж: “Энэ хууль нь адилтгалын хуультай илэрхий зөрчилдөхийн учир нь, нэг хуулийг баримталваас ямар нэгэн юм зөвхөн өөртөйгөө адилсах харьцаанд бай ёстой байтал нөгөө хууль нь түүнийг өөртөйгөө эсрэг, өөр харьцаанд байх ёстой гэ үздэг”/1/ нь утга төгөлдөр бус гэжээ. Үүний нэгэн адилаар гуравдахийг үгүйсгэх хууль зөрчлөөс зайлсхийхийг оролдохдоо үнэн хэрэгтээ зөрчилд ордог ажээ. Формал логикийн талаарх Гегелийн энэ шүүмжлэл зарим талаар үндэслэлтэй боловч түүний диалектик аргыг эсэргүүцэгчид, ялангуяа Вольфын логикийн сургуулийг баримтлагчид формал логикийн сэтгэлгээнд туйлын давуу ач холбогдол өгч байсан учир сэтгэхүйн диалектик аргыг тунхаглахын төлөөх тэмцлийнхээ нэгэн хэсгийг Гегель шүүмжлэлийн ий хэлбэрээр илэрхийлсэн байж болох юм.

Гегелийн энэхүү шүүмжлэл нь формал логикийг үгүйсгэсэн хэрэг огт бус бөгөөд тэрбээр формал логикийг огт хэрэггүй зүйл гэж үзээгүйгээр үл барам зохих хэмжээний ач тустай болохыг онцолсон байдаг. “Формал логикийг судлах нь зохих хэмжээний ашиг тустай гэдэг нь эргэлзээгүй. Формал логикийг судалбал ухаан хурцалдаг гэж ярьдаг”/2/ хэмээн “Логикийн ухаан” зохиолдоо тэмдэглэсэн буй. Түүний үзлээр, сэтгэхүйн логик тодорхойлолтууд нь өөрсдөө төөрөгдөлд оруулдаггүй боловч энгийн, өрөөсгөл тодорхойлолтуудыг туйлын үнэн мэтээр үнэлдэг явдалд хэргийн учир оршдог байна. “Сэтгэхүйн өрөөсгөл тодорхойлолтуудыг саланги тусгаар байдлаар авч үздэгт шинжлэгч сэтгэгч метафизикийн догматик баримтлал орших бөгөөд оюун ухааны философийн үзэл баримтлал нь үүний эсрэг цогц авч үзэх зарчмыг удирдлага болгож шинжлэгч сэтгэлгээний хийсвэр, өрөөсгөл тодорхойлолтуудын хязгаарыг гэтэлдэг” /3/ болохыг Гегель нотлохыг хичээжээ.

Формал логикийн хуулиудаас диалектик татгалзах ёстой гэж Гегель үзээгүй бөгөөд сэтгэхүйн диалектик аргын өөрийнх нь механизм логикийн хуулиудыг дагаж мөрдөхийг шаарддаг болно. Үүний нэгэн тод жишээг “Логикийн ухаан” зохиолынх нь ерөнхий бүтцээс харж болно. Нэг ойлголт нөгөөдөө шилжиж, тэр нь дахиад гуравдахь ойлголтон шилжих гэх мэтээр үргэлжилдэг нь үнэн хэрэгтээ эхний ойлголт өөрөө зөрчилтэй учир түүний эсрэг ойлголтыг нь харгалзан үзэх шаардлага гардаг бөгөөд энэхүү зөрчлийг

арилгахын тулд тэдгээрийг нийлэгжүүлсэн шинэ ойлголтонд шилжих хэрэгтэй болдог ажээ. Ийм шилжилтүүд хязгааргүй үргэлжлэх мэт боловч сэтгэлгээний эцсийн үр дүн төгс догцолбор үнэн байх ёстой учир дотоод зөрчилгүй, зохистой байх ёстой. Энэ бол формал логикийн хуулийг мөрдөж буй хэрэг юм. Үнэнд хүрэх үйл явц зөрчилтэй байх боловч эцсийн үр дүн нь зөрчилгүй байх ёстой гэсэн диалектикийн шаардлага формал логиктой зөрчилдөхгүй гэж хэлж болно.

Зөрчил байна гэдэг бол төгс бусын шинж бөгөөд зөрчлийг даван туулж арилгах нь сэтгэхүйн диалектикийн гол хөдөлгөч хүч нь байдаг. Зөрчил өөрөө үнэнийг илэрхийлдэг байсан бол диалектик үйл явцын тухай сэтгэх боломжгүй бөгөөд энэ тухай ярих ч шаардлагагүй юм. Сэтгэхүйн эцсийн үнэн зөрчилгүй төгс зохиролтой байх ёстой гэсэн Гегелийн баримтлал Аристотелийн логикийг үгүйсгэж буй хэрэг бус, харин түүнийг нөхөн үйцээж буй хэрэг гэж үзэж болно.

Логикийн шинжлэх ухааны гол судлагдахуун нь сэтгэхүйн хэлбэрүүдийн хууль, зарчмуудын тухай асуудал байдгийг Гегель анхаарч үзсэн хэдий боловч энэхүү судлагдахуун нь уламжлалт формал логикийн судлагдахуунаас ялгаатай байх ёстой гэдэг үндэслэлийг дэвшүүлжээ. Түүний үзлээр, логик бол сэтгэхүйн абсолют хэлбэрийн тухай шинжлэх ухаан байх ёстой ажээ. Сэтгэхүйн абсолют хэлбэрийн тодорхойлолт нь өөрийнхөө агуулгыг илэрхийлсэн үнэн байх ёстой гэдэг утгаараа уламжлалт логикийн судлагдахуунаас ялгаатай болохыг тэр бээр тэмдэглэсэн байдаг. Энэхүү хэлбэр нь "ердийн логик хэлбэрээс огт өөр уг чанартай байна. Энэ хэлбэр өөрөө үнэн байх учир нь агуулга хэлбэртээ тохирсон буюу ойлголтондоо тохирсон бодит чанар байхад оршино" /4/.

Сэтгэхүйн хэлбэрийн асуудлыг авч үзэхдээ Гегель шинжлэгч сэтгэхүй ба оюун ухааны үүргүүд, тэдгээрийн харилцан холбооны асуудлыг ихээхэн анхаарсан байдаг. Шинжлэгч сэтгэхүйн хэлбэрүүдийг формал логикт судалдаг боловч тэдгээрийг саланги тусгаар байдлаар шинжилдгээс метафизик сэтгэлгээ үүдэлтэй гэж үзээд тэдгээрийг диалектик харилцаанд нь судлахад логикийн шинжлэх ухааны зорилго оршино гэсэн байр суурьнаас асуудалд хандаж байсан учир өөрийн гол бүтээлээ "Логикийн ухаан" гэж нэрлэсэн нь санамсаргүй хэрэг биш юм.

Логик сэтгэлгээний үйл явц харилцан уялдаа бүхий гурван үе шатыг дамжин хэрэгждэг тухай үзэл санааг Гегель "Философийн шинжлэх ухааны нэвтэрхий толь" зохиолдоо дэвшүүлсэн байдаг. Логик сэтгэлгээ нь хэлбэрийн хувьд : "а / хийсвэр буюу шинжлэгч сэтгэлгээ, б / диалектик буюу негатив сэтгэлгээ, в / спекулятив буюу позитив сэтгэлгээ" / 5/ гэсэн шатлалыг дамжин хэрэгжинэ гэж тэрбээр үзэж байв. Эдгээр шатлалууд нь биеэ даасан тусгаар үйл явц бус, харин сэтгэхүйн хэлбэр бүхэнд зайлшгүй байх эгшнүүд болохыг онцлон анхааруулж "энэхүү гурван эгшин эхний буюу шинжлэгч сэтгэлгээний шатанд ч байж болно /5/ гэсэн буй.

Логик сэтгэлгээний эхний шатанд мэдлэгийн агуулгыг задлан хуваарилаж, тус тусад нь тусгаар байдлаар, эн зэрэгцүүлэн авч үздэг учир шинжлэгч сэтгэлгээ гэж нэрлэсэн ажээ. Энэ шатанд ойлголтуудын тусгаар тодорхойлолтуудыг шинжилдэг бөгөөд энэ утгаараа метафизик сэтгэлгээний хэлбэр формал шинжтэй болдог байна. Логик сэтгэлгээний үйл явцыг цаг хугацааны гурван шатлалд хуваасан бус, харилцан нягт уялдаа бүхий, гурван эгшинээс бүрдэнэ гэсэн, утгаар авч үзвэл, метафизик сэтгэлгээ бол, логик сэтгэлгээний салшгүй нэгэн эгшин болох юм.

Шүүн шинжлэгч метафизик сэтгэлгээ өөрийнхөө хязгаараас халих тохиолдолд эсрэгтээ шилжиж диалектик буюу эсрэгцүүлэх сэтгэлгээний хэлбэрт хувирах бөгөөд "диалектик сэтгэлгээний эгшинг шинжлэгч сэтгэлгээнээс салангид тусгаар байдлаар авч

үзвэл шинжлэх ухаанд скептицизм үүсч, диалектикийн үр дүн нь хоосон үгүйсгэл болдог”/6/ байна. Логик сэтгэлгээний энэ хоёр эгшин тус тусдаа үнэнд хүрэхгүй боловч диалектик сэтгэлгээ нь мэдлэгийн агуулгыг зайлшгүй дотоод холбоо харилцаанд нь авч үздэг учир спекулятив буюу нотлон дүгнэх сэтгэлгээний эгшинд хүргэдэг ажээ. Логик сэтгэлгээний спекулятив эгшинд “ойлголтын тодорхойлолтын эсрэг тэсрэг байдлын нэгдэл бүрдэж позитив үр дүн бий болдог” байна. “Сэтгэлгээний шинжлэгч эгшинд тус тусдаа эсрэг тэсрэг хэлбэрээрээ үнэнд тооцогдож байсан тодорхойлолтууд нэгдэлд орж нийлэгжсэнээр үнэн тодорхой болох” /7/ учир формал логикийн тодорхойлолтууд спекулятив логикт агуулагдаж байх ёстой ажээ.

Логикийн шинжлэх ухааны судлагдахуун нь сэтгэхүй мөн боловч “формал сэтгэхүй бус, харин өөрийн тодорхойлолт, хуулиудаа цогц байдлаар төгөлдөржүүлэн баяжуулж байдаг сэтгэхүйн үйл явцыг судлах ёстой” /8/ гэсэн үзэл санааг Гегель баримталж байжээ. Сэтгэхүйг формал байдлаар судлахын дутагдлыг “сэтгэхүйн гадаад хэлбэр гэж ихэвчлэн үздэг зүйлсийг түүний агуулгатай нь хамт судалснаар арилгаж болно” /9/ гэсэн үзэл санаа Гегелийн диалектикийн гол цөм нь болдог.

Сэтгэхүйн хэлбэрийг философийн тусгай судлагдахуун болгосон тэдгээр философийн танин мэдэхүйн чухал амжилт болохыг Гегель хүлээн зөвшөөрч байв. “Сэтгэхүйн хэлбэрүүдийг тусгаар зүйл болгон судлах болсон нь маш их дэвшил болсон гэж эн тэргүүнээ үзэх хэрэгтэй. Үүнийг бид Платон, ялангуяа Аристотелийн сургаалаас харж болох бөгөөд ингэснээр тэдгээрийг танин мэдэх үйл эхэлдэг” боловч сэтгэхүйн тодорхойлолтуудыг зөвхөн түүний гадаад хэлбэр мэтээр авч үздэг явдал уламжлалт логикийн нэгэн дутагдал мөн. “Логик сэтгэлгээний хэлбэрүүдийг агуулгагүй болгосон нь тэдгээрийг авч үзэх, тайлбарлах аргатай нь зөвхөн холбоотой юм. Логик агуулгаас ангид гэж үздэг нь логикийн судлагдахууны буруу биш, харин түүнийг ойлгох аргаас л үүдэлтэй” /10/ болохыг Гегель анхааруулсан байдаг.

Логикийн судлагдахуун зөвхөн танин мэдэхүйн хэлбэрийн асуудалтай холбоотой болох тухай үзэл санаа хожуу үеийн философийн сургаалд ч байсны нэгэн жишээ бол Кантын үзэл баримтлал юм. Кантын үзлээр, философийн категориуд онтологийн агуулгагүй бөгөөд зөвхөн бодомжийн хэлбэрүүдэд харгалзах оюун ухааны априори хэлбэрүүд болдог. Танин мэдэхүйн априори хэлбэрүүдийг тусгайлан судлах гэсэн Кантын оролдлогыг Гегель усанд орохгүйгээр сэлж сурах гэсэнтэй адилтган ёгтлон шүүмжилсэн байдаг. Ийм шүүмжлэл зарим талаар үнэний хувьтай юм.

Гегелийн үзлээр, формал логикийн хүрээнд үнэний тухай асуудлыг ярих боломжгүй бөгөөд “формал үнэн” гэдэг бол зөвхөн “зөв эсэх” тухай асуудалтай л холбоотой юм.

Ишлэл авсан бүтээлүүд

1. Г.В.Гегель. Наука логики. Соч., т.1. М., 1974. с.203.
2. Мөн тэнд. 47 дахь тал.
3. Мөн тэнд. 70 дахь тал.
4. Г.В.Гегель. Соч., т.6. с.23.
5. Г.В.Гегель. Соч., т.1. с.201-202.
6. Мөн тэнд. 135 дахь тал.
7. Мөн тэнд 139-140 дэх тал.
8. Мөн тэнд. 294 дэх тал.
9. Г.В.Гегель. Соч., т.5. с. 12.
10. Мөн тэнд. 25 дахь тал.